| 5 | Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал | 60’000 |
| **НИЙТ ЗАРДАЛ** | | **920,000** |

---oOo---

## “ЭРДГЕО” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “НҮХТИЙН ХЯР” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

| | |
|---|---|
| Хянасан огноо | |
| Хянасан мэргэжилтний хувийн дугаар | |
| **Дүгнэлт** | |
| Шийдвэрийн төсөл | |
| Ололт, амжилттай тал | |
| Дутагдалтай сул тал | |
| Шаардлага | |

### НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, баганад мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг *“хамааралгүй”* гэж бөглөнө.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|---|---|---|
| 1.1 | 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр | Эрдгео ХХК |
| | 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар | Гэрчилгээний дугаар:000293589<br>Хувийн хэргийн дугаар: 9011861949 |

| | | |
|---|---|---|
| | 3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл | - Геологи хайгуулын ажил эрхлэх<br>- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа<br>- Ашигт малтмалын олборолт |
| | 4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 5-р хороолол, нарны зам, 18-р байр,11 тоот |
| | 5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг | Захирал Ж.Дашхорол,<br>утас: 99102445, 70119862<br>erdgeo@yahoo.com |
| | 6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг | Байгаль орчны мэргэжилтэн<br>Ш.Намсрайжав<br>утас: 88080733<br>цахим шуудангийн хаяг:<br>snamsraijav1@gmail.com |
| 1.2 | 1. Төслийн нэр | “Нүхтийн хяр” хайлуур жоншны орд |
| | 2. Төслийн харъяаллын байршил | Дундговь аймгийн Өлзийт сум, 5-р баг, “Нүхтийн хяр” уурхай |
| | 3. Төслийн ангилал | Уул уурхай |
| | а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт | Жонш |
| | б. ил уурхай, далд уурхай, шороон орд | Ил уурхай |
| | в. баяжуулах үйлдвэр | Үгүй |
| | 4. Төсөл эхэлсэн огноо | 2021 он |
| | 5. Төсөл хэрэгжих хугацаа | 2030 он |
| | 6. Уурхайн хаалт эхлэх огноо | Тодорхойгүй |
| | 7. Хаалтын дараах зориулалт | Бэлчээрийн зориулалтаар |
| | 8. ТЭЗҮ баталсан огноо | Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, ашигт малтмал, газрын тосны газар, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг 2020 оны 11 |

| | | |
|---|---|---|
| | | дүгээр сарын 27-ны өдрийн 074 дугаар Т/20-12-11 авсан. “Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн тушаал /дугаар Т/09/-аар ТЭЗҮ хүлээн авсан. 2026 онд дахин ТЭЗҮ батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. |
| | 9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/ | Эрдгео ХХК нь 2025 оны 1, 3, 5, 6, 7 дугаар сарууудад нийт 43 тонн жонш олборлосноос 17.5 тонн жонш тээвэрлэсэн. Одоогоор үлдэгдэл 25.5 тонн жонш байна. |
| | 10. Ажилчдын тоо | 40 |
| | 11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө | - |
| | 12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц | - |
| | 13. Замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл | - |
| | 14. Шатахуун түгээгүүрийн тоо | 1 хошуу бүхий 1 түгээгүүртэй |
| | 15. Шатахууны агуулахын агууламжийн хэмжээ | 10 тонны /м$^3$/ багтаамжтай 1 ширхэг хэвтээ савтай нийт 10 тонн багтаамжтай. |
| | 16. Тэслэх, дэлбэлэх бодисын агуулахын хүчин чадал гэх мэт | Байхгүй. |

## ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

· Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
· Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
· Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах баганад хавсралтын нэрийг оруулах

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|---|---|---|
| 2.1 | 1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар<br>Хүчинтэй хугацаа Талбай | Ашигт малтмалын ашиглалт<br>MV-021616<br>2050.07.08<br>495.54 га |
| | 2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/<br>Дугаар Хүчинтэй хугацаа | Үгүй<br>- |
| | 3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт | - |
| | 4. Галын дүгнэлтийн огноо, дугаар | Галын аюулын дүгнэлт, зөвшөөрлийг 2025 оны 02 дугаар сарын 06-нд гаргуулсан. 2026 оны 02 дугаар сарын 06-нд дууcна. Дундговь аймгийн Онцгой байдлын газар |
| | 5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд | БОННҮ-г Биофера ХХК-аар хийлгүүлж 2020 оны 06 дугаар сарын 4-ны өдөр 13/4041, Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| | 6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд | 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдөр, Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| | 7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо | Дундговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2025.12.05-ны өдрийн дугаар E-2510-000144 дүгнэлт авсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо | | | 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр |
| | 9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах | | | Хавсаргав: |
| | 10. Нөхөн сэргээлт | Төлөвлөгдсөн. | тайлант онд гүйцэтгэсэн | 0.1 га |
| | | Төлөвлөгдсөн. | төлөвлөгөөт онд гүйцэтгэх | 0.1 га |
| | 11. ТХГН-ын тухай хууль, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах | | | www.eic.mn-ээс Кадастрын лавлагааг цахимаар татан авч хавсаргав. |
| | | | | |

## ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугээр сарын 29-ны өдрын А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтанд тусгагдсанг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/
- Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт **“хангалттай”** гэсэн дүгнэлтийг оруулна.
    - урьдчилан сэргийлэх арга хэмжээ
    - эрсдлийн үед авах арга хэмжээ
    - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ
    - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ

- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хэсэг |
|---|---|---|
| 3.1 | 1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/ | Байхгүй |
| | 2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө<br>- урьдчилан сэргийлэх арга хэмжээ<br>- эрсдлийн үед авах арга хэмжээ<br>- учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ<br>- хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ | - |
| 3.2 | 1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх<br>2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх | - Дизелийн түлшний 10 тонны / м3/ багтаамжтай хэвтээ 1 ширхэг савтай нийт 10 тонн багтаамжтай зөөврийн ШТС-тай.<br>- Байхгүй |
| 3.3. | 1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж тонн/<br>· Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/<br>· Дахин ашиглагдах хог хаягдал<br>· Аюултай, хортой хог хаягдал | -<br>10 тонн<br>0,04 тос, 21 дугуй |
| | 2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв | 1,776,000 төгрөг |

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

- Доорх хүснэгтийн 4.12 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хэсэг |
|---|---|---|
| 4.1 | 1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв | **Нийт төсөв- 12,420,000 төг** |
| | 2. Сөрөг өлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв | 1’000’000 |
| | 3. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/ | - |
| | 4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв | 5’000’000 |
| | 5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв | - |
| | 6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв | - |
| | 7. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв | - |
| | 8. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв | 920’000 |
| | 9. Осол эрдслийн менежментийн төлөвлөгөө | 0 |
| | 10. Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал | 500’000 |

| | | |
|---|---|---|
| | 11. Нөхөн сэргээлт, Ногоон байгууламж, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | 5’000’000 |
| | | |

## ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.
- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг |
|---|---|---|
| 5.1 | Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл | |
| | Тосгон | |
| | Хог хаягдлын цэгийн байршил | |
| | Аюултай хог хаягдлын агуулахын байршил | |
| | Хаягдлын далан | |
| | Химийн бодисын агуулахын байршил | |
| | Орчны хяналт шинжилгээний дээж авах | |
| | Хяналтын цэгийн байршил | |
| | Тухайн жилд хуулах хөрс | |
| | Гадаад, дотоод овоолго | |
| | Техникийн нөхөн сэргээлтийн талбай | |
| | Биологийн нөхөн сэргээлтийн талбай | |
| | Гүний худгийн байршил | |
| | Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил | |

## ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь баганад **“тодорхойлсон”**, **“тодорхойлоогүй” “хамааралгүй”** гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

| Нөлөөллийн ангилал | А. Тооцсон эсэх | Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх | В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх | Г.Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| 6. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл<br>· Бохирдуулах<br>· Эвдэх<br>· Доройтуулах | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | |
| 6. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл<br>· Бохирдуулах<br>· Нөөцийг бууруулах | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл<br><br>· амьдрах орчинг хуваах<br>· амьдрах орчинг доройтуулах<br>· амьдрах орчинг хомсдуулах<br>· нөөцийг бууруулах | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | |
| 6. Агаарт үзүүлэх нөлөөлөл<br><br>· Бохирдуулах<br>· тоос | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | |
| 6. Түүх соёлын дурсгалт эд зүйлс<br><br>· Хамгаалах<br>· Нүүлгэн шилжүүлэх | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | |

## ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн **“А”** баганaнд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн **“Б”, “В”,** баганaнд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд **“тийм”, “үгүй”** хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн **“Г”** баганaнд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнгүүд **“хангалттай” “хангалтгүй”** гэсэн дүгнэлт өгнө.

| Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл | А. Тоо | Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх | В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх | Г.Дүгнэлт |
|---|---|---|---|---|
| 7. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ | 11 | Тийм | Тийм | |
| 7. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 4 | Тийм | Тийм | |
| 7. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ<br>· техникийн/ га ээзлхүүн<br>· биологийн /га | 1 | Тийм | Тийм | |
| 7. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ | 2 | Тийм | Тийм | |
| 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ | 2 | Тийм | Тийм | |
| 7. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ | Хамааралгүй | Хамааралгүй | Хамааралгүй | |
| 7. Байгаль орчны менежментинй удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 3 | Тийм | Тийм | |

## НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг **“А, Б, В, Г”** багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

| Хяналт шинжилгээний дээж | А. Дээж авах цэгийн тоо | Б. Дээж авах цэгийн байршил | В. Давтамж (удаа) | Г. Төсөв (төг) |
|---|---|---|---|---|
| 1. Хөрс | 7 | Шатахуун түгээх станц, соруулдаг эко нойл, кемп, шимт хөрсний овоолго, хаягдлын овоолго, засварын цэг, техникийн зогсоол | 4 | - |
| 2. Ус | 1 | Малчны худаг | 4 | - |
| 3. Амьтан | 1 | Тусгай зөвшөөрлийн талбайг хамрах | 1 | - |
| 4. Ургамал | 1 | Тээвэрлэлтийн зам, өдөр тутмын үйл ажиллагааны зам, уурхайн хашааны гадна дээж талбай сонгосон. | 2 | - |
| 5. Агаар | 4 | Жонш ялгалтын хэсэг, тээвэрлэлтийн зам, ажилчдын хотхон, шатахуун түгээх станц, | 4 | - |

-0-

# БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

***Байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудит***

Аудитын тайлантай танилцаж хүлээн авсан:

| Нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |

**2025 он**

| | |
|---|---|
| **АУДИТЫН ТАЙЛАНГИЙН №** | **БОЛОВСРУУЛСАН ОГНОО** |
| EAR2025/27 | 2025.10.13 |
| **ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА** | **ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ** |
| “ЭЙ ЭЙ МӨНХЖИН НОМУУН” ХХК | |
| **АУДИТ ХИЙХ ТӨСӨЛ** | **АУДИТ ХИЙХ БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ** |
| "Нүхтийн хяр" хайлуур жоншны орд ашиглах төсөл | Дундговь аймгийн Өлзийт сум |
| **АУДИТЫН ТӨРӨЛ** | **АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:** |
| Байгаль орчны нийцлийн аудит | Байгаль орчны хууль тогтоомж болон БОННҮ-ний хэрэгжилтийн биелэлт |
| **АУДИТЫН ХЯЗГААРЛАХ ХҮРЭЭ** | **АУДИТЫН ШАЛГУУР** |
| БО-ноос бусад хууль тогтоомж | Байгаль орчны багц хууль, журмууд болон БОННҮ-ний заалтууд |
| **АУДИТ ХИЙСЭН ХУГАЦАА:** | **ӨМНӨХ АУДИТ ХИЙСЭН ХУГАЦАА** |
| 2025 оны 10-р сарын 03-15-ны өдөр | Анхны |

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

“ЭЙ ЭЙ МӨНХЖИН НОМУУН” ХХК–ийн “Нүхтийн хяр" хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагаанд “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн 10[1] дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны багц хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, тогтоол, байгаль орчны стандартуудын заалтууд болон үйлчлүүлэгч байгууллагын 2021 онд хийгдсэн БОННҮ-ний тайлангийн хэрэгжилтийн нийцлийн аудитыг 2025 оны 10-р сарын 03-15-ны өдрүүдийн хооронд хийж гүйцэтгэв.

Тус байгаль орчны аудитыг төслийн БОННҮ болон бусад БО-ны баримт бичгүүдийн хяналт, төслийн талбай дээрх шалгалт, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага болон цуглуулсан баримт нотолгоонд үндэслэн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг үндсэн үйл ажиллагааны дагуу хийв.

“ЭЙ ЭЙ МӨНХЖИН НОМУУН” ХХК–ийн “Нүхтийн хяр" хайлуур жоншны орд ашиглах төсөл 2021 оноос үйл ажиллагаагаа явуулж бөгөөд өдгөө 4 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байгаа юм.

Төслийн үйл ажиллагаанууд нь хууль эрх зүйн хувьд нийт 285 зүйл заалтаас хамаарал бүхий 155 зүйл заалтын хэрэгжилтийг шалгахад нийцлийн 111 заалт буюу 71.61%, үл нийцэл 41 заалт буюу 26.45%, тодорхойгүй 4 заалт буюу 1.94% байлаа.

Хамааралгүй заалтуудад байгаль орчинтой хамааралгүй болон хэрхэн хэрэгжүүлэх журам нь гараагүй ус хомсдуулсны төлбөртэй холбоотой хуулийн заалтууд, үйл ажиллагаандаа аливаа төрлийн химийн бодис ашигладаггүй тул химийн хортой болон аюултай бодисын тухай хууль, тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой үйл ажиллагааг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлдэг, гэрээт байгууллага нь хуулийн хэрэгжилтээ хариуцаж байгаа тул энэхүү заалтад хамаарч байгаа болно.

Аудитын хугацаанд үйлчлүүлэгч байгууллагын холбогдох ажилтнууд дэмжин хамтран ажилласан бөгөөд ямар нэгэн саад тотгор, хөндлөнгөөс нөлөөлөх байдал гараагүй болно.

**Гарын үсэг:**

УЛААНБААТАР ХОТ ЭНВАЙРОМЕНТАЛ КОМПЛАЙНЦ ХХК ХТУ3898 5652928

**Огноо:** 2025.10.15

**Б.Энхбаяр, Ахлах аудитор**


Хаяг: Далай тауэр 403 тоот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гий гудамж 31 Улаанбаатар 14230, Монгол улс
Утас: +976 70000802
Гар утас: 99083500
Имэйл: enheecz@gmail.com

## Тайлангийн агуулга

1 Байгаль орчны аудит....5
1.1 Байгаль орчны аудитын зорилго, зорилт....5
1.2 Байгаль орчны аудитын хамрах хүрээ....5
2 Байгаль орчны аудитын үйл ажиллагаа....6
2.1 БОА-ын багийн бүрэлдэхүүн....6
2.2 БОА-ын үйл явц....6
3 Байгаль орчны аудитын үр дүн....6
3.1 Хууль тогтоомжийн нийцлийн үнэлгээний үр дүн....7
4 Байгаль орчны аудитын зөвлөмж....9


Хаяг: Далай тауэр 403 тоот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гий гудамж 31 Улаанбаатар 14230, Монгол улс
Утас: +976 70000802
Гар утас: 99083500
Имэйл: enheecz@gmail.com

# 1 Байгаль орчны аудит

## 1.1 Байгаль орчны аудитын зорилго, зорилт

“ЭЙ ЭЙ МӨНХЖИН НОМУУН” ХХК–ийн “Нүхтийн хяр" хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагаанд “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн $10^1$ дугаар зүйлд заасны дагуу байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудит хийж, улмаар уурхайн одоогийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, засаж залруулах арга хэмжээ авах арга зам, цаашид байнгын сайжруулах боломж бий болгож улмаар компанид учирч болзошгүй эрсдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх болон орон нутгийн иргэд, ажилчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бий болгоход нь тусалж дүгнэлт, зөвлөмж өгөх нь энэхүү аудитын ажлын үндсэн зорилго оршино.

Байгаль орчны аудитын ажлын үндсэн зорилгодоо хүрэхийн тулд дараах дэд зорилтуудыг биелүүлж ажиллаа. Үүнд:

- “ЭЙ ЭЙ МӨНХЖИН НОМУУН” ХХК–ийн “"Нүхтийн хяр" хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журам, стандарт, БОННҮ-ний шаардлагыг олж тогтоох
- Тэдгээр хууль, дүрэм, журам стандартууд, БОННҮ-ний шаардлагыг уурхайн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх
- Аудитаар илэрсэн зүйлст дүгнэлт, зөвлөмж өгөх
- Цаашид сайжруулах арга хэмжээг тусгах

## 1.2 Байгаль орчны аудитын хамрах хүрээ

“ЭЙ ЭЙ МӨНХЖИН НОМУУН” ХХК–ийн “Нүхтийн хяр" хайлуур жоншны орд ашиглах төслийн дараах нэгж, байгууламжуудад БО-ний хууль тогтоомж нийцлийн болон БОННҮ-ний хэрэгжилтийн аудит хийлээ. Үүнд:

- Жоншны ил уурхай
- Сайжруулсан авто зам
- Аюултай хог хаягдлын цэг
- Ариун цэврийн байгууламж


Хаяг: Далай тауэр 403 тоот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гий гудамж 31 Улаанбаатар 14230, Монгол улс
Утас: +976 70000802
Гар утас: 99083500
Имэйл: enheecz@gmail.com

- Засвар үйлчилгээ явуулж байгаа талбай

Байгаль орчны холбогдолтойгоос бусад хууль тогтоомж, стандартын шаардлага хамаарахгүй болно.

# 2 Байгаль орчны аудитын үйл ажиллагаа

## 2.1 БОА-ын багийн бүрэлдэхүүн

- Ахлах аудитор: Б.Энхбаяр
- Аудитор: Б.Номин-эрдэнэ
- Туслах аудитор: П.Галмандах

## 2.2 БОА-ын үйл явц

Аудитын төлөвлөгөөний дагуу үндсэн 3 үе шатаар нийт 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

**Аудитын 1-р үе шат** буюу Бэлтгэл ажил болон баримт бичгийн хяналтын ажлыг 2025.10.03-ны өдрөөс эхлэн өөрийн компанийн байранд нийт 2 өдөр ажиллаа.

**Аудитын 2-р үе шат** буюу төслийн талбайд ажиллаж мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2025.10.09-ны өдөр “ЭЙ ЭЙ МӨНХЖИН НОМУУН” ХХК–ийн Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Нүхтийн хяр" хайлуур жоншны орд ашиглах төслийн талбайд 1 өдөр ажиллаа.

**Аудитын 3-р үе шат** буюу дүгнэлт, зөвлөмж боловсруулахаар өөрийн компанийн байранд 7 өдрийн хугацаанд ажиллаа.

# 3 Байгаль орчны аудитын үр дүн

Энэхүү бүлэгт БО-ны аудитын үйл ажиллагаагаар илэрсэн байгаль орчны хууль тогтоомжийн шаардлагууд тус бүрийн нийцлийн үнэлгээ, илэрсэн зөрчил, доголдол бүрийн тэмдэглэлийг нэгтгэв. БО-ны аудитыг Захиалагч компанийн дараах бичиг баримтуудад хийв. Үүнд:

- БОМТ, түүний хэрэгжилтийн тайлангууд
- Газар, ус ашиглах гэрээ
- Газар, ус ашигласны болон агаар, ус бохирдуулсны төлбөр төлсөн баримтууд
- Лабораторийн шинжилгээний дүнгүүд
- Тусгай зөвшөөрлүүд, тэдгээртэй холбоотой захирамж, тогтоол, дүгнэлтүүд

болон бусад ашиглалтын үйл ажиллагаанд БО-ны асуудлуудтай хамааралтай бичиг баримтууд

Аудитын явцад илэрсэн үр дүнг дараах байдлаар дүгнэв. Үүнд:

**Т:** Тохирол (хэрэгжүүлж байгаа болон хэрэгжсэн)

**ҮТ:** Үл тохирол (хэрэгжүүлээгүй)

**Т-гүй:** Тодорхойгүй (тухайн шаардлага өөрөө ойлгомжгүй, эсвэл тухайн шаардлагыг хэрэгжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй, нотолгоогүй, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй)

**Х-гүй:** Хамаарахгүй заалт (тухайн хууль тогтоомжид заасан БО-ны үүрэг хариуцлагын заалт нь уурхайн үйл ажиллагаанд хамаарахгүй байгаа заалтууд)

гэсэн үнэлгээ өгч ажилласан бөгөөд үр дүнг дүгнэв.

## 3.1 Хууль тогтоомжийн нийцлийн үнэлгээний үр дүн

Төслийн үйл ажиллагаанууд нь хууль эрх зүйн хувьд нийт 285 зүйл заалтаас хамаарал бүхий 155 зүйл заалтын хэрэгжилтийг шалгахад нийцлийн 111 заалт буюу 71.61%, үл нийцэл 41 заалт буюу 26.45%, тодорхойгүй 4 заалт буюу 1.94% байлаа.

Хамааралгүй заалтуудад байгаль орчинтой хамааралгүй болон хэрхэн хэрэгжүүлэх журам нь гараагүй ус хомсдуулсны төлбөртэй холбоотой хуулийн заалтууд, үйл ажиллагаандаа аливаа төрлийн химийн бодис ашигладаггүй тул химийн хортой болон аюултай бодисын тухай хууль, тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой үйл ажиллагааг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлдэг, гэрээт байгууллага нь хуулийн хэрэгжилтээ хариуцаж байгаа тул энэхүү заалтад хамаарч байгаа болно.


Хаяг: Далай тауэр 403 тоот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гий гудамж 31 Улаанбаатар 14230, Монгол улс
Утас: +976 70000802
Гар утас: 99083500
Имэйл: enheecz@gmail.com

**Хүснэгт 3-1**

| Эрх зүйн баримт бичиг | т | т-гүй | үт | х-гүй | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Агаар | 5 | | 5 | 7 | 17 |
| Агаарын бохирдлын төлбөрийн тухай | 3 | | | 4 | 7 |
| Агаарын тухай хууль | 2 | | 5 | 3 | 10 |
| Амьтан & ургамал | | | | 7 | 7 |
| Амьтны тухай хууль | | | | 1 | 1 |
| Байгалийн ургамлын тухай | | | | 2 | 2 |
| Ойн тухай | | | | 4 | 4 |
| Ашигт малтмал | 15 | 1 | 9 | 4 | 29 |
| Ашигт малтмалын тухай | 15 | 1 | 9 | 4 | 29 |
| БО-ны тухай | 22 | | 8 | 8 | 38 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль | 2 | | | 2 | 4 |
| Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай | 7 | | 5 | 3 | 15 |
| Байгаль орчныг хамгаалах тухай | 13 | | 3 | 1 | 17 |
| Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай | | | | 2 | 2 |
| Газар & хөрс | 44 | 2 | 3 | 14 | 63 |
| Газрын төлбөрийн тухай | 2 | | | 3 | 5 |
| Газрын тухай | 27 | 2 | 1 | 1 | 31 |
| Газрын хэвлийн тухай | 10 | | | 1 | 11 |
| Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай | 5 | | 2 | 9 | 16 |
| Тусгай хамгаалалт, соёлын өв | 9 | | | 1 | 10 |
| Соёлын өвийг хамгаалах тухай | 9 | | | | 9 |
| Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай | | | | 1 | 1 |
| Ус | | | 8 | 32 | 40 |
| Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох, тухай | | | | 2 | 2 |
| Ус бохирдуулсны төлбөрийн тухай | | | 4 | 1 | 5 |
| Усны тухай | | | 4 | 29 | 33 |
| Химийн бодис & Хог хаягдал | 16 | | 8 | 57 | 81 |
| Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай | | | | 22 | 22 |
| Химийн хорт болон аюултай бодисын тухай | | | | 32 | 32 |
| Хог хаягдлын тухай | 16 | | 8 | 3 | 27 |
| **Тоогоор** | **111** | **3** | **41** | **130** | **285** |
| **Хувиар** | **71.61** | **1.94** | **26.45** | | **100%** |

# 4 Байгаль орчны аудитын зөвлөмж

Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа "ЭЙ ЭЙ МӨНХЖИН НОМУУН" ХХК–ийн "Нүхтийн хяр" хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагаанд аудит хийх явцад илэрсэн үл тохирол ба эдгээр үл тохирлыг хэрхэн засах, аудитын явцад хийж гүйцээгүй болон хийгдэж байгаа арга хэмжээнүүдэд дараах зөвлөмжүүдийг өглөө. Энэхүү зөвлөмжид зарим авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд багтсан болно. Үүнд:

1. Байгаль орчны үнэлгээний тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.1-т заасны дагуу тухайн жилийн БОМТ-г боловсруулан өмнөх оны БОМТ-ний биелэлтийн тайланг орон нутгийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу байгаль орчны газарт хүргүүлэхдээ хамт хүргүүлж санал авч байх.
2. Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг дүгнүүлсэн актыг гарсны дараа БОМТ-г байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яаманд батлуулахаар хүргүүлэх. Батлуулахаас өмнө тухайн жилийн БОМТ-ний зардлын 50 хувийг тусгай дансанд байршуулах.
3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-рт заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх үүрэгтэй байдаг тул байгаль орчны ажилтантай болох.
4. Тухайн жилийн БОМТ-нд заасны дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагад хандаж хийлгэж байх.
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.2-т заасны дагуу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн оршин суугчид болон төслийн нөлөөлөлд өртөгчдөд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж байх. Багийн иргэдийн нийтийн хурал болох үед байгууллагаас төлөөлөл байлгаж тайлангаа товч танилцуулж байх.
6. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21.3.1-21.3.2-т заасны дагуу хог хаягдлаа зориулалтын газарт зөвшөөрөгдсөн аргаар зайлуулах арга хэмжээг авч ажиллах. Хог хаягдлыг тухай хуулийн

10.2.3-10.2.4-т заасны дагуу Орон нутгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хог хаягдлаа аймгийн засаг даргын тогтоосон зориулалтын цэгт зайлуулж байх.

7. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-д заасны дагуу **байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт**ийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх гэдэг шаардлагын дагуу ажиллах.
8. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1-10.2.2-т заасны дагуу хог хаягдлыг ангилан ялгаж хаях нөхцөлөөр нь хангаж өгөх. Ингэхийн тулд ажилтнуудад хог хаягдал ангилан хаях талаар сургалт зохион байгуулах, ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савууд байрлуулах гэх мэт
9. Хог хаягдлын цэгийг тохижуулан зориулалтын хог сав байрлуулан ашиглах. Хог хаягдлын тухай хуулийн 15-р зүйлд заасан шаардлага хангахуйц хогийн сав байх.
10. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5-т заасны дагуу үүсгэсэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллага буюу хортой, аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан иргэн, аж ахуйн нэгжид хүлээлгэн өгөх.
11. Хог хаягдлын тухай хуулийн 10.3.6 болон Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.2-д тус тус заасны дагуу одоо ашиглаж байгаа 2 нүхэн жорлонг нэн даруй ариутган цэвэрлэж хааж усны тухай хуулийн 24.4-т заасан журмын дагуу засаж тохижуулан, өөрийн хүчин чадалд тохирсон цэвэрлэх байгууламжийг байгуулах.
12. Энгийн хог хаягдлыг ногоон бүс, үерийн суваг даланд хаях хориотой байдаг тул сайр руу түрж хаясан байгаа хогийг авч зориулалтын хог сав болон цэгт зайлуулж орчныг цэвэрлэх
13. Хог хаягдлын тухай хуулийн 10.3.3-т хог хаягдлын ил задгай шатаахыг хориглодог тул цаашид дахиж шатаахгүйгээр зориулалтын хогийн сав болон цэгт зайлуулж хэвших.
14. Хог хаягдлын тухай хуулийн 21.1-д заасны дагуу аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж бүртгэлийн дугаар авах. Аймгийн байгаль орчны газарт албан бичгээр хандаж уг дугаарыг авна.
15. Аюултай хог хаягдлыг хог хаягдлын тухай хуулийн 23.3-т заасан шаардлага хангасан орчинд хадгалах


Хаяг: Далай тауэр 403 тоот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гий гудамж 31 Улаанбаатар 14230, Монгол улс
Утас: +976 70000802
Гар утас: 99083500
Имэйл: enheecz@gmail.com

16. Гаргаж байгаа аюултай хог хаягдлаа хог хаягдлын тухай хуулийн 23.4-т заасны дагуу нэр төрөл бүрээр нь бүртгэж байх.
17. Аюултай хог хаягдлыг хог хаягдлын тухай хуулийн 10.2.5-д заасан эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх
18. Усны тухай хуулийн 24.4-т заасны дагуу ахуйн бохир ус зайлуулах цэгээ тохижуулан ашиглах
19. Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг сав газрын дүгнэлтийг үндэслэн сумын засаг даргаас авах. Сумын засаг даргын тогтоосон цэгт хаягдал усаа зайлуулж тухайн зайлуулсан хэмжээгээрээ ус бохирдуулсны төлбөр төлөх
20. Газрын тухай хуулийн 34.8-д заасны дагуу газар эзэмших гэрээг сумын газрын даамалд хандаж жил бүр дүгнүүлж байх.

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлээд хэрхэн хэрэгжүүлсэн тайлангаа дараагийн төлөвлөгөөт аудит хийгдэхээс өмнө орон нутгийн байгаль орчны албанд хүргүүлэх.

Б.Энхбаяр

Энвайроментал комплайнц ХХК-ийн

Захирал, Ахлах аудитор,

УЛААНБААТАР ХОТ
ЭНВАЙРОМЕНТАЛ КОМПЛАЙНЦ ХХК
ХТУ3898 5652928

Environmental Compliance
Хаяг: Далай тауэр 403 тоот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31 Улаанбаатар 14230, Монгол улс
Утас: +976 70000802
Гар утас: 99083500
Имэйл: enheecz@gmail.com

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000293589

2006.01.19
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011861949
/ Хувийн хэргийн дугаар /

2104989
/ Регистрийн дугаар /

Эрдгео — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 001 | 1998.03.05 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 7490 | Геологи хайгуулын ажил эрхлэх /-/ |
| 09100 | Ашигт малтмалын хайгуулын /2018.11.21-2021.11.21/ |
| 46100 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |
| 08990 | Ашигт малтмалын олборлолт /2024.01.24-2054.01.24/ |

| Хугацаагүй | 2 | 3,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, 5 хороолол, нарны зам, 18-р байр 11 тоот, Утас1: 99102445, Утас2: 99997434, Факс: 70119862
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — Г.АЛТАНЗАЯА
/тэмдэг/ /гарын үсэг/

*Гэрчилгээ дахин олгосон 2024 он 03 сар 05 өдөр*

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Жанчив овогтой Дашхорол-г Захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | *2006.01.19* | *А.Дэнсмаа* |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2024.03.05* | *Г.Алтанзаяа* |

УЛСЫН БҮРТГЭГЧ

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000293589

## АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

# АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ***MV-021616***

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

***Дундговь*** аймаг /хот/-ийн

***Өлзийт*** сум /дүүрэг/-ын

***Нүхтийн булаг*** нэртэй газарт орших

***495.54*** гектар талбай бүхий уурхайн талбайд

хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн ***2011004028*** тоот гэрчилгээтэй

***"Эрдгео" ХХК*** -д

энэхүү тусгай зөвшөөрлийг ***2050.07.08*** дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ОДОНЧИМЭГ

2020 оны 7 сарын 8 өдөр

Улаанбаатар хот

0000470

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-021616**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Огноо, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| 001-NM | • Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2020.07.08, дуусах хугацаа 2050.07.08<br>• Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв<br>• Кадастрын хэлтсийн даргын 2020.07.07-ний 236 тоот шийдвэр | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595<br>2020.07.08 |
| 002-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.07.08 – 2022.07.08 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595<br>2021.07.22 |
| 003-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.07.08 – 2023.07.08 хүртэл | 1 АМГТГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043<br>2022.07.06 |
| 004-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.07.08 – 2024.07.08 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043<br>2023.06.12 |
| 005-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2024.07.08 – 2025.07.08 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043<br>2024.06.06 |
| 006-FE | • Баталсан: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2025.07.08 – 2026.07.08 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043<br>2025.06.13 |
| | | |

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

**MV-021616**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/ | Хасагдах талбайн хэмжээ /га/ | Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | # | Уртраг | Өргөрөг |
| 001-NM | • Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2020.07.08 | 495.54 Га | 0 Га | 1 | 106° 31' 1.42" | 45° 15' 3.53" |
| | | | | 2 | 106° 29' 20.57" | 45° 15' 3.53" |
| | | | | 3 | 106° 29' 20.57" | 45° 16' 16.57" |
| | | | | 4 | 106° 31' 1.42" | 45° 16' 16.57" |
| | | | | 2020-07-08 Д.Чинзориг | | |

# ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2025 он 05 дугаар сарын 13 өдөр № 03 Рашаант

## Нэг . Нийтлэг үндэслэл

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2,6 дахь заалт , Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 40 тоот тогтоолыг тус тус үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

## Хоёр. Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас **Дундговь аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ыг** төлөөлж Засаг дарга **Адъяадорж** овогтой **Жавхлан** нөгөө талаас Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 18-р хороо, Стадион оргил, Нийслэл хүрээ, өргөн чөлөө гудамж, Роял гарден 28/7-р байр 1 тоот хаягтай, **2011001028** тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, **2104989** тоот регистрийн дугаартай Дундговь аймгийн Өлзийт суман дахь "Нүхтийн булаг" нэртэй газарт ашиглалтын **MY-021616** тусгай зөвшөөрөл эзэмшигч "**Эрдгео**" ХХК-ны захирал **Ж.Дашхорол** нар харилцан тохиролцож 2025 оны 12 сарын 31- ний өдөр хүртэл энэхүү гэрээг байгуулав.

## Гурав. Төлбөр тооцсон байдал

Өлзийт сумын ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 40 дүгээр тоот тогтоолын 25-д заасны дагуу уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжид хог хаягдал гаргасны 1 сарын төлбөрийг **148.000** төгрөгөөр тооцож ашиглалтын ажил явагдах 12 сард нийт 1.776.000 төгрөгөөр тооцов.

## Дөрөв. Сумын ЗДТГ эрх, үүрэг

1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
2. Иргэд аж ахуйн нэгж , байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх
3. Иргэд аж ахуйн нэгж , байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих

## Тав. Иргэн ААН байгууллагын эрх үүрэг

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.

2. ААН байгууллага нь хог хаягдал гарсан төлбөрөө 2 дугаар улиралд багтаан ноогдуулсан төлбөрийн дагуу нэхэмжлэхээр төлнө. /төрийн сан банк/
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах.
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллэх.
10. Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газарт ноогдуулсан төлбөрийн дагуу нэхэмжлэхээр төлбөрөө төлөх.

**Зургаа. Гэрээний хариуцлага**

1. Аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгуулагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
2. Аж ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ДУНДГОВЬ АЙМАГ ӨЛЗИЙТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА................/А.ЖАВХЛАН/
УТАС:88887527

"ЭРДГЕО" ХХК-ны захирал ......................
........................ Ж.ДАШХОРОЛ
УТАС: ....................

Батлав:

"ЭРДГЕО"ХХК-ийн

ЗАХИРАЛ Ж.ДАШХОРОЛ

Батлав:

"АШИД ТАВАН ЭРДЭНЭ"ХХК-ийн

ЗАХИРАЛ Б.АМАРЖАРГАЛ

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021616 АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААРТАЙ "НҮХТИЙН БУЛАГ" НЭРТЭЙ ТӨСӨЛ, MV-022751 АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААРТАЙ "УУШИГ УУЛ-1" НЭРТЭЙ ТӨСӨЛ ТУС БҮРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ, БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БОЛОВСРУУЛАН БАТЛУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ

2025 оны 05-р сарын 13–ны өдөр № Улаанбаатар хот

## Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээг нэг талаас **"ЭРДГЕО"ХХК** /цаашид "ЗАХИАЛАГЧ" гэх/, нөгөө талаас **"АШИД ТАВАН ЭРДЭНЭ"ХХК** /цаашид "ГҮЙЦЭТГЭГЧ" гэх, хамтад нь "ТАЛУУД" гэх/ нар харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь ЗАХИАЛАГЧИЙН дараах төслүүдийн байгаль орчны төлөв байдлын тайлан хийх, БОУАӨЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төсөл тус бүрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах, БОУАӨЯ-ны мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлэн батлуулах зэргийг ГҮЙЦЭТГЭГЧ тал хийх бөгөөд ЗАХИАЛАГЧ нь уг ажлын үр дүнг хүлээн авах, ГҮЙЦЭТГЭГЧИД ажлын хөлс төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших MV-021616 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаартай "Нүхтийн булаг" нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл,
- Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших MV-022751 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаартай "Уушиг уул-1" нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл,

## Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

**2.1 ЗАХИАЛАГЧ-ийн үүрэг:**

2.1.1 Бэлтгэл ажлын хэмжээ болон гүйцэтгэх хугацааны талаар ГҮЙЦЭТГЭГЧ-тэй харилцан тохирох, төслийн даалгавар, нөхцөлийг тодорхой өгөх;

2.1.2 ГҮЙЦЭТГЭГЧ ажлаа гүйцэтгэх үед шаардагдах баримт бичиг, судалгаа, тооцоо, мэдээллээр цаг хугацаанд нь түргэн шуурхай хангах, өгсөн аливаа мэдээллийнхээ үнэн зөв болон чанарт хариуцлага хүлээх;

2.1.3 Объект, түүний орчинд шаардлагатай хэмжилт, судалгаа хийх бололцоо нөхцөлөөр хангах;

2.1.4 Объектийн үйл ажиллагаа, технологийн асуудлыг танилцуулах, мэдээлэл зөвлөгөө өгөх хүнийг томилж, ажилд туслалцаа үзүүлэх

2.1.5 Энэ гэрээний дагуу ГҮЙЦЭТГЭГЧ-ийн үзүүлсэн үйлчилгээний хөлсийг цаг хугацаанд нь бүрэн төлөх;

2.1.6 ГҮЙЦЭТГЭГЧ-тэй хамтран төсөл хэрэгжиж буй орон нутгийн иргэдэд төслийн үйл ажиллагаа, төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хэлэлцүүлэх.

**2.2 ЗАХИАЛАГЧ-ийн эрх:**

2.2.1 Гүйцэтгэгчийг ажлаа хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх талаар шаардлага тавих;

2.2.2 Энэ гэрээний хүрээнд гарган өгсөн болон боловсруулсан мэдээллийн нууцыг чандлан хадгалахыг ГҮЙЦЭТГЭГЧ-ээс шаардах;

**2.2.3** Ажлын явцтай танилцах, түүнд дүн шинжилгээ хийх

## Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

**3.1 ГҮЙЦЭТГЭГЧ-ийн үүрэг:**

3.1.1 ГҮЙЦЭТГЭГЧ нь уг гэрээний 1.2-т заасан нэр бүхий ажлыг мэргэжлийн ур чадвар гарган гүйцэтгэх

3.1.2 Төсөлтэй холбоотой бүхий л материалыг ЗАХИАЛАГЧ талаас бүрэн гаргуулж, өмнө хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнг бүрэн шингээх

3.1.3 Хийж гүйцэтгэсэн ажлын эцсийн тайланг хэвлэмэл байдлаар захиалагч талд хүлээлгэн өгөх. Үүнд:
- Байгаль орчны төлөв байдлын суурь судалгааны тайлан 2 хувь
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2 хувь

3.1.4 Захиалагч талаас шалтгаалан төсөл боловсруулах болон хянуулах ажил аль нэг шатандаа зогсоход хүрвэл захиалагч талд даруй мэдэгдэх, харилцан ярилцах,

3.1.5 Төслийн байршил, төслийн үйл ажиллагаа нь байгаль орчны аливаа хууль тогтоомж, стандартыг зөрчиж түүнтэй холбоотойгоор Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргахаас татгалзвал гүйцэтгэгч нь үүрэг хүлээхгүй бөгөөд төслийн байгаль орчны төлөв байдлын тайлан боловсруулсан төлбөрийг Захиалагчаас бүрэн гаргуулна.

3.1.6 Төслийн байршил, төслийн үйл ажиллагаа нь байгаль орчны аливаа хууль тогтоомж, стандартыг зөрчиж байгаа нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тодорхой болох, БОУАӨЯ-ны мэргэжлийн зөвлөл тайлан батлахаас татгалзвал гүйцэтгэгч нь үүрэг хүлээхгүй бөгөөд төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулсан төлбөрийг Захиалагчаас бүрэн гаргуулна.

**3.2 ГҮЙЦЭТГЭГЧ-ийн эрх:**

3.2.1 ЗАХИАЛАГЧ мэдээллийг цаг хугацаа алдаж өгөх, буруу мэдээллийг дахин залруулах зэргээс үүдэн гэрээт ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа хойшилбол хариуцлага хүлээхгүй;

3.2.2 ЗАХИАЛАГЧ-аас ажлын хөлсийг цаг хугацаанд нь төлөхийг шаардах;

3.2.3 ЗАХИАЛАГЧ Төслийг эрсдэл багатай, алдаа мадаггүй боловсруулахын тулд төслийн талбайд явуулсан бүхий л баримт бичгийг судлан үзэх боломжийг ЗАХИАЛАГЧ талтай харилцан тохиролцох

## Дөрөв. ТАЛУУД-ын хүлээх хариуцлага

4.1 ТАЛУУД энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монгол Улсад үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.2 Захиалагч нь гүйцэтгэгчийн шаардсан материалыг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсвэл төсөл нэгэнт боловсруулагдан дуусаад шинжээчид хүргүүлсэн хойно төсөлд өөрчлөлт оруулах санал захиалагч гаргах, орон нутгаас авсан зөвшөөрөл, тодорхойлолт нь хүчингүй, орон нутгийн иргэдийн тэмцэл хөдөлгөөн зэргээс хамааран ажил зогсох, цаашид үргэлжлүүлэх боломжгүй болох зэрэг зүйлсд гүйцэтгэгч хариуцлага хүлээхгүй бөгөөд тухайн үед хийж гүйцэтгэгдсэн ажлын төлбөрийг бүрэн гаргуулах, захиалагчийн саналаар өөрчлөлт оруулвал нэмэлт ажлын төлбөрийг захиалагч тал хариуцана.

4.3 ЗАХИАЛАГЧ гэрээний төлбөрийг цаг хугацаандаа шилжүүлээгүй тохиолдолд гэрээний төлөгдөөгүй үнийн дүнгээс хоногт 0,1 хувиар алданги тооцож ГҮЙЦЭТГЭГЧ-д төлнө.

4.4 Гэрээнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийж, гарын үсэг зурж тамга дарсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

4.5 Талууд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аль нэг тал нь гэрээгээ цуцалсан тохиолдолд гүйцэтгэсэн ажлыг харилцан дүгнэж, гэрээний дагуу үлдсэн ажлын хэмжээг тохиролцож асуудлыг шийдүүлнэ.

## Тав. Гэрээний төлбөр

5.1. Гэрээт ажлын үнийн дүн нь дараах дүнтэй байна.

| № | Гүйцэтгэх ажил | Нийт төсөв /төг/ |
|---|---|---|
| 1 | MV-021616 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаартай "Нүхтийн булаг" нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл | 32 000 000 |
| 2 | MV-022751 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаартай "Уушиг уул-1" нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл | 27 000 000 |
| | НӨАТ 10% | 5 900 000 |
| | **ГЭРЭЭНИЙ ДҮН** | **64 900 000** |

5.2 Төлбөрийн нөхцөл

- Урьдчилгаа төлбөр болох нийт төлбөрийн 70% болох **45,430,000.0** /Дөчин таван сая дөрвөн зуун гучин мянга/ төгрөг-ийг гэрээ батлагдсан өдөр гүйцэтгэгч байгууллагад нэхэмжлэхийн дагуу төлөх.
- "Нүхтийн булаг" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ БОУАӨЯ-д батлагдсан өдөр нэхэмжлэхийн дагуу Гүйцэтгэгч талд үлдэгдэл төлбөр 30% болох **10,560,000.0** /Арван сая таван зуун жаран мянган төгрөг /-ийг Захиалагч тал олгоно.
- "Уушиг уул-1" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ БОУАӨЯ-д батлагдсан өдөр нэхэмжлэхийн дагуу Гүйцэтгэгч талд үлдэгдэл төлбөр 30% болох **8,910,000.0** /Найман сая есөн зуун арван мянган төгрөг /-ийг Захиалагч тал олгоно.

## Зургаа. Бусад

6.1 Энэнхүү гэрээ нь ТАЛУУД харилцан гарын үсэг зурж тамга дарсанаархүчин төгөлдөр болно.

6.2 ТАЛУУД гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд санаачлагч ТАЛ ажлын 2 хоногийн өмнө бичгээр мэдэгдэж өөрчлөлт оруулна. Энэхүү өөрчлөлт нь ТАЛУУД гарын үсэг зурснаар баталгаажна.

6.3 Гэрээг 2 хувь үйлдэж ТАЛ тус бүр нэг, нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль, эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| "ЗАХИАЛАГЧ"-ийг төлөөлөн: | "ГҮЙЦЭТГЭГЧ"-ийг төлөөлөн: |
| "Эрдгео"ХХК-ийн | "Ашид Таван Эрдэнэ" ХХК-ийн |
| Захирал Ж.Дашхорол | Захирал Б.Амаржаргал |
| Утас: 99102445 | Утас: 88103619 |

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 12 дугаар сарын 19-ны өдөр Дугаар: 05 Рашаант

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Усны тухай хуулийн 29.1-д заасныг үндэслэн Дундговь аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Е-2510-000144 дугаар дүгнэлт, Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/163 тоот захирамжийн дагуу ус ашиглуулагчийг төлөөлж Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг дарга А.Жавхлан, ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо, Стадион оргил, Нийслэл хүрээ, Өргөн чөлөө гудамж, Роял гарден хотхон, 28/7 дугаар байр, 1 тоот хаягт байрлах, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 2011001028, регистрийн дугаар 2104989 бүхий Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дахь "Нүхтийн булаг" нэртэй талбайд ашиглалтын MY-021616 дугаар тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдгео" ХХК-ийн захирал Ж.Дашхорол нар энэхүү гэрээг 2025 оны хайгуул, уулын ажлын хүрээнд байгууллаа.

---

## ХОЁР. УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН МЭДЭЭЛЭЛ

2.1. **Ус ашиглах зориулалт:**
Унд, ахуйн хэрэгцээ, төслийн талбайн 2025 оны ашиглалтын үйл ажиллагааны хүрээнд зам талбайн тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглана.

2.2. **Ашиглах усны хэмжээ:**
Нийт 8,016.00 м³

2.2.1. Үүнээс:

- Унд, ахуйн болон зам талбайн тоосжилт дарахад – 7,200.00 м³
- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар – 600.00 м³
- Ногоон байгууламжийн усалгаанд – 216.00 м³

**Нийт:** 8,016.00 м³

2.3.**Усны чанар, найрлага:**
Газрын доорх ус, шинжилгээ хийгдээгүй.

2.4. **Усны эх үүсвэрийн байршил:**
Унд, ахуйн хэрэглээ болон зам талбайн тоосжилт дарахад ашиглах усыг 1.5 л/сек

ундаргатай, 80 метрийн гүнтэй, 8.8 метрийн түвшинтэй, өөрийн уурхайн “Сайр” нэртэй гүний худгаас ашиглана.

2.5. **Хаягдал усны хэмжээ:**
Хаягдал ус гарахгүй, стандартын шаардлага хангасан.

2.6. **Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:**
Хамаарахгүй.

